

*Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны
саналын дагуу хийсэн аудитын тайлан*

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа



**САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРЭН ХЭМЖЭЭГЭЭР АШИГЛААГҮЙ,
ЗАРИМ СУМДАД ХЯНАЛТ ОРХИГДСОН БАЙНА**

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал *Д.Ганбилэг*

Хөвсгөл аймгийн ерөнхий аудитор *О.Ганболд*

Аудитын менежер
Ж.Отгончимэг

Ахлах аудитор
Г.Нямлхагва

Шинжээч *Б.Сандуйжав*

2012 оны 9 дүгээр сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.
www.mnao.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	3
Үндсэн мэдээлэл	3
Бүлэг 1. Банкны шалгуур хангасан иргэд төсөлд хамрагдаж байна	5
Бүлэг 2. Зээлийн ашиглалтад тавьж буй хяналт хангалтгүй байна	9
2.1 Зээлийн ашиглалтад тавьж буй хяналт хангалтгүйгээс төслийн үр дүн сумдад харилцан адилгүй байна	9
2.2 Зээлийн эргэн төлөлтөд банк хяналт тавьж байна	10
Дүгнэлт	12
Зөвлөмж	13
ХАВСРАЛТУУД:	
Хавсралт №1	14
Хавсралт №2	15
Хавсралт №3	20
Хавсралт №4	21
Хавсралт №5	22
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	25

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэнгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Аудит нь дараахь зорилтын хүрээнд хийгдэж, дүгнэлт зөвлөмж гарган үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдсэн болно. Үүнд:

- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн хөрөнгийн зарцуулалт үр дүнтэй эсэх,
- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн зээлийн ашиглалтад хяналт тавьж байгаа эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын ХБХ, СТСХ, ХААН банкны Хөвсгөл аймаг дахь салбар, сумдын ЗДТГ-ын “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн мэргэжилтэн, төсөл сонгон шалгаруулах хороо, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл аван үйл ажиллагаа явуулж буй зарим ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа хамрагдлаа.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх хугацаа богино байснаас шалтгаалан зээлийн хэрэгжилтийг бүх сумдад газар дээр нь очиж үзэх боломжгүй байсан тул сумд болон банкнаас авсан судалгаанд тулгуурласан бөгөөд зарим сумдыг /Баянзүрх, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Хатгал, Мөрөн/ түүвэрлэж аудит хийсэн болно.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласнаас гадна холбогдох газруудад аудитын горимын дагуу асуудлыг шинжлэн судлах, асуулга, ярилцлага хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2009 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан” төслийг хэрэгжүүлэхээр 400.0 сая төгрөг батлагдсан байна. Энэ хөрөнгийг Мөрөн суманд 80.0 сая, Хатгал тосгонд 12.0 сая, бусад сумдад тус бүр 14.0 сая төгрөг олгохоор хуваарилсан байна.

Сангийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 2009 оны 6 дугаар сарын 1-ний өдөр аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нар, Зоос банкны захиралтай “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” байгуулан сарын 1 хувийн хүүтэй зээл хэлбэрээр олгохоор болжээ. Энэ хугацаанд Зоос банк нийт 141.6 сая төгрөгийн зээл олгосон байна.

2009 оны 11 дүгээр сараас Зоос банкаар зээлийг цаашид үргэлжлүүлэн олгох боломжгүй болсон тул 2009 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр аймгийн Засаг дарга, ХААН банкны захиралтай “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” гэрээ байгуулжээ.

Төсөл хэрэгжиж ирсэн хугацаанд зээлийн гэрээг 4 удаа шинэчилсэн байна. Үүнд:

- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” 1 дугаартай гэрээг 2009 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр,
- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” 2 дугаартай гэрээг 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдөр,
- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” 1 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээг 2009 оны 12 дугаар сарын эцэст,
- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” 5 дугаартай гэрээг 2011 оны 9 дүгээр сарын 26-ны өдрүүдэд тус тус шинэчлэн байгуулсан байна.

2011 оны 5 дугаар гэрээний 5.5-д “энэхүү гэрээ байгуулагдсанаар энэ асуудлаар өмнө нь байгуулагдсан бүх гэрээ, хэлцэл тохиролцоо хүчингүй болно” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар сүүлийн 5 дугаар гэрээг мөрдөн ажиллаж байна. /Гэрээг хавсралт 5-д үзүүлэв/

Сангийн хөрөнгийг ХААН банкинд татан авахдаа нийт эх үүсвэрийн 258.4 сая төгрөгийг үлдэгдэл санхүүжилтээс, 141.6 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс шилжүүлж төвлөрүүлсэн байна.

Бүлэг 1. Банкны шалгуур хангасан иргэд төсөлд хамрагдаж байна

1.1 “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн бага хүүтэй зээлд хамрагдахыг хүссэн иргэдийн төслийг сумын Засаг даргаар ахлуулсан “Төсөл шалгаруулах хороо” шалгаруулаад ХААН банкинд хүргүүлдэг байна.

1.2 2009 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр ХААН банкны ахлах мэргэжилтэн Б.Болортуяагаас ирүүлсэн санамж бичигт зээлийн нөхцөлийг “бизнесийн зээлийн ” гэсний дагуу Аймгийн Засаг дарга, ХААН банкны захиралтай байгуулсан гэрээний 3.2.2-т “Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцсэн төслүүдийг судлах, дүгнэлт гаргах болон шийдвэрлэхдээ зөвхөн өөрийн байгууллагын дотоод журам зааврыг баримтлах ба зээл олгох эсэх шийдвэрийг банк бие даан гаргана ...” гэж заажээ.

1.3 Банк сумын Төсөл шалгаруулах хорооноос дэмжигдсэн төслөөс өөрийн банкны шалгуурыг хангасан зээлдэгчдэд 12-24 сарын хугацаатай зээлийг олгожээ. /Банкны зээлийн шалгуурыг хавсралт 1-д үзүүлэв/

Хүснэгт №1

БАНКНЫ ШАЛГУУР ХАНГАЖ ЗЭЭЛ ОЛГОСОН БАЙДАЛ

Он	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	Зээлийн эх үүсвэрийн эхний үлдэгдэл	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн эргэн төлөлт	Зээлийн эх үүсвэрийн эцсийн үлдэгдэл
2009	206	400.0	346.1		53.9
2010	96	53.9	147.3	303.0	209.6
2011	176	209.6	336.7	247.1	120.0
2012	38	120.0	91.5	162.8	191.3
Дүн	516	-	921.6	712.9	-

Дэлгэрэнгүйг хавсралт 2-2.4-ээс үзнэ үү.

1.4 Дээрх хүснэгтээс дараахь тоон мэдээг харж болох юм. Үүнд:

- Нийт 516 өрхөд 921.6 сая төгрөгийн зээл олгосон,
- 2009 онд Зоос банк 141.6 сая төгрөг, ХААН банк 204.5 сая төгрөг, нийт 346.1 сая төгрөгийн зээл олгосон.
- Нийт 921.6 сая төгрөгийн зээлийн анхны эх үүсвэр болох 400.0 сая төгрөг 2.3 дахин эргэлтэд орсон,
- 921.6 сая төгрөгийг 3 жилийн хугацаанд олгосон гэвэл жилд 0.8 удаа буюу жилд олгосон зээлийн 77.0 хувь нь эргэн төлөгдсөн.
- Нийт олгосон зээлээс төлөгдөх хугацаа болоогүй зээлийн үлдэгдэл 208,7 сая төгрөг байна. /2012 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар/

1.5 Зээлийн ашиглагдаагүй эх үүсвэр оны эцсийн байдлаар 53.9 – 191.3 сая төгрөг байгаа нь зээлийг бүрэн хэмжээгээр ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

1.6 Зарим сумдыг түүвэрлэн авч хэдэн өрхөд, хичнээн төгрөгийн зээл олгосон байдлыг харьцуулж үзүүлбэл:

Хүснэгт №2

Сайн жишээ			Муу жишээ		
Сумын нэр	Өрхийн тоо	Олгосон зээл /сая төг/	Сумын нэр	Өрхийн тоо	Олгосон зээл /сая төг/
Жаргалант	47	52.4	Түнэл	5	14.0
Тариалан	32	50.5	Чандмань-Өндөр	9	33.1
Цагааннуур	33	53.5	Эрдэнэбулган	9	22.8
Хатгал	42	38.7			

1.7 Зээлийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байгаа шалтгааныг авч үзвэл:

- Гэрээний 3.2.12-т “Сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийн тухай ерөнхий тоон мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаж, “А” талд мэдэгдэнэ” гэж заасан хэдий ч банк гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс ямар төсөл нь банкны шалгуур хангаж зээл авсан болон буцсан, хэдий хэмжээний зээлийн эх үүсвэр банканд байгаа талаар мэдээлэл сумын удирдлагад дутмаг байна.


Зээлийн эргэн төлөлтөөс зээлд хамрагдахыг хүссэн иргэдийн төслийг шалгаруулан ХААН банкинд хүргэх ажил ч тогтмолжоогүй байна.

- 2012 оны ӨҮДС-гийн чөлөөт үлдэгдэл их байгаа нь 1, 2, 3 дугаар сард зээл олгоогүйтэй холбоотой бөгөөд ХААН банкнаас ирүүлсэн судалгаанд “гэрээ байгуулсан байгууллагын хүсэлтийн дагуу зээл олгогдоогүй” гэсэн байна.

Гэрээ байгуулсан аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Х.Ган-Очироос тодруулга авахад зээлийг зогсоох тухай мэдэгдээгүй гэсэн хариу өгсөн боловч аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав 2012 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1/21 дүгээр албан бичгээр ХААН банкинд саналаа хүргүүлжээ. Энэ бичгийн дагуу ХААН банк зээлийн эх үүсвэрийг аймгийн “Үйлдвэржилтийг дэмжих сан”-д төвлөрүүлэн зээл олголтыг зогсоосон байна. Албан бичгийн хувийг /Зураг 1/-ээс, дансны үлдэгдлийг /хавсралт 3/-аас харна уу.

- Гэсэн ч энэ талаар ХААН банкны сумдын зарим салбарын эрхлэгч нар нэгдсэн ойлголтгүй байв. Тухайлбал, Алаг-Эрдэнэ сумын ХААН банкны салбарын эрхлэгч С.Чулуун ӨГҮДС-гийн зээлийг ЖДҮДС-ийн зээл олголтын шийдвэртэй андуурч зогсоосон нь миний буруу гэсэн тайлбар өгч байлаа.

Зураг 1. ХААН банкинд хүргүүлсэн бичиг




- Гэрээний 2.3-т "Мөнгөн хөрөнгө байршуулах: А талын байршуулах мөнгөн хөрөнгийг В талын банкны 5890750177 тоот "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн санхүүжилт" нэртэй дансанд байршуулна. Зээлийн сангийн мөнгөн хөрөнгөд гэрээний хугацаанд хүү тооцохгүй." гэж заасан нь сангийн мөнгөн хөрөнгө хүүгээр өсөх боломж нөхцөлийг хязгаарласан байна.

1.8 Гэрээний 3.2.2-т "Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцсэн төслүүдийг судлах, дүгнэлт гаргах болон шийдвэрлэхдээ зөвхөн өөрийн байгууллагын дотоод журам зааврыг баримтлах ба зээл олгох эсэх шийдвэрийг бие даан гаргана.

“В” тал нь уг хороогоор хэлэлцэж батлаагүй төслийг хүлээн авахгүй байх эрхтэй” гэж заасан атал шалгаруулах хороогоор хэлэлцээгүй төсөлд Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын орлогч М.Сэрээнэнгийн зээл олгох тухай гараар үйлдсэн баримтыг үндэслэн ХААН банкны эрхлэгч С.Чулуун зээл олгосон байна.

Зураг 2. Хаан банкинд хүргүүлсэн баримт



1.9 Түүнчлэн Гэрээний 3.2.3-т “ ... зээлийг сумдын захиргааны харъяалалд байнга оршин суудаг бөгөөд “Б” талын зээлийн журмын шаардлага хангасан этгээдэд олгох” гэжээ. Гэтэл Алаг-Эрдэнэ сумын төсөл шалгаруулах хороо нь Мөрөн сумын харъяат иргэн С.Батбаярын төслийг дэмжин ХААН банкинд хүргүүлж жил бүр 5,0 сая төгрөгийн зээл олгосон байна.

1.10 ӨГҮДС-гийн хөрөнгийг сарын 1 хувийн хүүтэйгээр зээлдэгч нарт олгож байгаа ба хүүгийн орлого нь банкинд үлдэж байна.

1.11 2012 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхтуяа ХААН банкны Хөвсгөл аймаг дахь салбарын ерөнхий нягтлан бодогч Ч.Оюунтөгс нар улсын төсвийн хөрөнгө оруулалтын 400.0 сая төгрөгийг сумдын иргэд, аж ахуйн нэгжид зээл олгох санхүүжилтийн эх үүсвэр хэлбэрээр байршуулсныг баталгаажуулан тооцоо нийлжээ. Тооцоо нийлсэн актыг /хавсралт 4/-өөс үзнэ үү.

1.12 Өнөөдрийн байдлаар сангийн хөрөнгийн эхний эх үүсвэр болох 400.0 сая төгрөг банкны харилцах дансанд байршиж байгаа боловч орон нутгийн хувьд бүртгэлгүй, эргэн төлөлт болон зээлийн эцсийн үлдэгдлийн талаар мэдээлэлгүй байна.

Бүлэг 2. Зээлийн ашиглалтад тавьж буй хяналт хангалтгүй байна

Зээлийн ашиглалтад тавьж буй хяналт хангалтгүйгээс төслийн үр дүн сумдад харилцан адилгүй байна

- 2.1.1 Зээлийн ашиглалт, үр дүн нь зээл олголтос ихээхэн хамааралтай байна. Сангийн хөрөнгийн ашиглалт, үлдэгдлийн судалгаанаас үзэхэд Их-Уул, Тариалан, Цагааннуур, Хатгал зэрэг сумд сангийн хөрөнгийг бүрэн зарцуулсан байхад Ханх, Баянзүрх, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Түнэл зэрэг сумд 12.0-13.0 сая төгрөгийн чөлөөт үлдэгдэлтэй, сангийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, орон нутгийн удирдлага зээлийг үр дүнтэй ашиглах талаар санаачлага муутай ажиллаж байна.
- 2.1.2 Хатгал тосгоны тухайд өрх гэрийн үйлдвэрлэл, бизнес эрхлэхэд зах зээлийн таатай орчин бүрдсэн боловч “тосгон” гэсэн статусаас болоод аливаа төсөл хөтөлбөрт хамрагдах боломж муу, тосгоны иргэдийн үйлдвэрлэл үйлчилгээгээ хөгжүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.
- 2.1.3 Өнөөдрийн байдлаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн 12,0 сая төгрөгөөс өөр төсөл хөтөлбөр тус тосгонд хэрэгжээгүй байна.
- 2.1.4 ӨГҮДС-гийн зээлийн үр дүнгийн талаар сумдаас авсан судалгаагаар ажлын байр, өрхийн орлого нэмэгдсэн байна.
- 2.1.5 Зээлийг үр өгөөжтэй ашиглаж байгаа жишээг үзүүлбэл:

Зураг 3. Жижиг дунд үйлдвэр эрхлэгч



Арбулаг сумын иргэн
Ц.Уранчимэгийн оёдлын цех



Арбулаг сумын иргэн
Ж.Оюунтунгалагийн талхны цех

Зураг 4: Жижиг дунд үйлдвэр эрхлэгч



Хатгал тосгоны иргэн Х.Бат-Эрдэнийн гэрийн модон эдлэлийн жижиг цех

2.1.6 Зээлийг зориулалт бусаар зарцуулсан жишээг үзүүлбэл:

Зураг 5: Зээлийг зориулалт бусаар ашиглаж буй иргэд



Арбулаг сумын эмийн эргэлтийн санд зээл олгосон байдал



Хатгал тосгоны иргэн н.Бумандэмбэрэлийн хөрөө рам

2.2. Зээлийн эргэн төлөлтөд банк хяналт тавьж байна

2.2.1 Зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа болон зээлийн эргэн төлөлтөд хэрхэн хяналт тавьсан, ямар зөрчил илэрч үүрэг өгөгдсөн талаарх тайлан алга байгаа нь гэрээ байгуулсан аймгийн ЗДТГ-ын ХБХ болон орон нутгийн удирдлагын зүгээс тавьж буй хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

- 2.2.2 2011 онд сумдын ЗДТГ-ын бүтцэд жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний орон тоо бий болж, “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүрэг хүлээсэн боловч тухайн мэргэжилтний ажлын хариуцлагагүй байдлаас хяналт хангалтгүй байна. Тухайлбал: Алаг-Эрдэнэ сумын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Д.Энхсансарт энэ зээлийг хэдэн хүнд олгосон, зориулалтын дагуу зарцуулсан эсэх, хэрхэн хяналт тавьсан тухай тайлан, мэдээ баримт алга байна.
- 2.2.3 “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-ний 3.2.10-д *“Зээлийн судалгаа хийх, шийдвэрлэх, олгох, зээлд хяналт тавих, эргэн төлөлттэй холбогдон гарч болох бүх эрсдлийг “В” тал хариуцна.”* гэж заасны дагуу банк хяналтын үүргийг гүйцэтгэж байна. Банкны тавьж буй хяналт нь зээлийн эргэн төлөлтөд л чиглэгдэж байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн эх үүсвэр 400.0 сая төгрөг нь 3 жилийн хугацаанд 2.3 дахин эргэлтэд орж нийт 516 өрхөд 921.6 сая төгрөгийн зээл олгожээ. Найдваргүй болон хугацаа хэтэрсэн зээлгүй байна.
- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн 400.0 сая төгрөг нь ХААН банкны 58900023110000005 тоот “Үйлдвэржилт дэмжих сан” дансанд байршиж байгаа ба 2012 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар 208.7 сая төгрөг зээлийн эргэлтэд, 191.3 сая төгрөг чөлөөт үлдэгдлээр байгаа нь зээлийн эх үүсвэрийг тухай бүрт нь бүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.
- Зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд орон нутгийн зүгээс тавьж буй хяналт хангалтгүй, гэрээнд аливаа эрсдлийг банк хариуцна гэж заасны дагуу банк хяналтын үүргийг гүйцэтгэж байна. Банкны хяналт нь зөвхөн зээлийн эргэн төлөлтөд чиглэгдэж байна.
- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-г харилцан тохиролцож байгуулсан гэх боловч банкны эрх ашигт нийцүүлсэн нь орон нутгийн оролцоог хязгаарласан төдийгүй “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих төсөл” бус банкны зээл болон хувирсан байна.
- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн эхний санхүүжилт болох 400.0 сая төгрөг болон эргэн төлөлт, зээлийн эцсийн үлдэгдэл орон нутгийн төрийн санд бүртгэлгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав, ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Х.Ган-Очир, ХААН банкны захирал Д.Цэцгээ нарт:

- “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” № 5-ын Ерөнхий нөхцөл, талуудын эрх үүргийн уялдааг сайжруулах, харилцан ашигтай буюу орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг гэрээнд оруулах талаар судлан үзэж шийдвэрлэх,
- Зээлийн олголт, ашиглалт, үр дүнд бүрэн хэмжээний шалгалт хийх, дээрх гэрээний зохих заалт, нөхцөл, шалгуурыг зөрчиж зээл олгосон, түүнд хяналт тавьж ажиллаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй аймаг орон нутгийн холбогдох албан тушаалтан, банкны ажилтнуудад хариуцлага тооцох,

Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Х.Ган-Очир, сумдын Засаг дарга нарт:

- “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг дээшлүүлэх талаар аймгийн ЗДТГ-ын ХБХ болон орон нутгийн удирдлага гэрээ байгуулан дүгнэж ажиллах,

Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Х.Ган-Очирт:

- Зээлийн ашиглалт, үр дүн муутай байгаа сумдын санхүүжилтийг эргүүлэн татах, нэн шаардлагатай байгаа Хатгал тосгон болон бусад шаардлагатай сумдад нэмж олгох боломж нөхцөлийг судлах,

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Г.Сувд, сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт:

- Сангийн хөрөнгийг орон нутгийн төрийн санд бүртгэлтэй болгох,

Сумдын Засаг дарга, Төсөл шалгаруулах хороонд:

- Зээлийн олголт, үлдэгдлийн талаар сумын иргэдэд ил тод мэдээлж байх.

Хавсралт №1

**Зээл авч буй харилцагч та доорх
баримт, материалыг бүрдүүлнэ үү.**

1. Өөрийн болон хамтран үүрэг гүйцэтгэгчийн/гэр бүлийн хүн/ иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар
2. Өөрийн болон хамтран үүрэг гүйцэтгэгчийн /гэр бүлийн хүн/ 1, 1 хувь цээж зураг
3. Багийн засаг даргын тодорхойлолт
4. Борлуулалтын орлогын түүвэр /Бизнес тус бүрээр/
5. Орлого хөтөлсөн анхан шатны баримт, хар данс, тооцоо
6. Бараа материалын үлдэгдлийн түүвэр, тоолж шалгасан акт
7. Хамтран ажилладаг байгууллагуудтай байгуулсан гэрээ, хэлцэл /Хүчин төгөлдөр байгаа/
8. Гадаад паспортын нотариатаар баталгаажуулсан хуулбар
9. Бизнесийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой доорхи материалуудыг бүрдүүлнэ:
 - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
 - Ажлын байрны дүгнэлт
 - Тохирлын гэрчилгээ
 - Галын аюулгүй байдлын дүгнэлт гэх мэт бусад холбогдох бичиг баримтууд
10. Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд:
 - ҮХХ-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
 - ҮХХ-ийн хамтран өмчлөгчдөөс авсан зөвшөөрөл, итгэмжлэл
 - ҮХХ-ийн газраас авсан лавлагаа
 - Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, өмчилсөн бол гэрчилгээ
 - Газрын кадастрын зураг
 - Тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон бусад холбогдох бичиг баримт
11. Компанитай бол компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, татварт бүртгүүлсэн дүрэм
12. Компанийн зээл авахын өмнөх улирлын татвар, аудитаар баталгаажсан тайлан
13. Хэрэв компани 1-ээс дээш гишүүнтэй бол тухайн гишүүдийн зээл авах талаар хийсэн хурлын протокол, зөвшөөрөл
14. Түрээсийн гэрээ, түрээсийн төлбөр төлсөн баримт



Хавсралт №2

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ҮЛДЭГДЛИЙН СУДАЛГАА

Сум	Нийт дүн					
	нийт санхүүжилт	Эргэн төлөлт	Өрхийн тоо	Олгосон зээл	Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл	Зээлийн эх үүсвэр
Алаг-Эрдэнэ	14,000,000	29,404,388	25	36,697,600	7,293,212	6,706,788
Арбулаг	14,000,000	22,003,415	19	27,000,000	4,996,585	9,003,415
Баянзүрх	14,000,000	38,981,725	27	39,700,000	718,275	13,281,725
Бүрэнтогтох	14,000,000	22,930,508	6	24,500,000	1,569,492	12,430,508
Галт	14,000,000	26,417,313	16	30,550,000	4,132,687	9,867,313
Жаргалант	14,000,000	45,455,294	47	52,400,000	6,944,706	7,055,294
Их-Уул	14,000,000	26,058,515	16	39,500,000	13,441,485	558,515
Рашаант	14,000,000	22,272,829	10	27,200,000	4,927,171	9,072,829
Ренчинлхүмбэ	14,000,000	16,989,378	19	28,000,000	11,010,622	2,989,378
Таривалан	14,000,000	36,961,346	32	50,550,000	13,588,654	411,346
Тосонцэнгэл	14,000,000	22,929,097	21	30,200,000	7,270,903	6,729,097
Төмөрбулаг	14,000,000	34,178,516	25	34,950,000	771,484	13,228,516
Түнэл	14,000,000	13,121,294	5	14,000,000	878,706	13,121,294
Улаан-Уул	14,000,000	17,199,556	18	27,500,000	10,300,444	3,699,556
Ханх	14,000,000	29,514,764	20	30,100,000	585,236	13,414,764
Хатгал	12,000,000	32,209,850	42	38,700,000	6,490,150	5,509,850
Цагааннуур	14,000,000	35,764,565	33	53,500,000	17,735,435	(3,735,435)
Цагаан-Уул	14,000,000	20,293,849	14	28,000,000	7,706,151	6,293,849
Цагаан-Үүр	14,000,000	20,721,799	10	28,000,000	7,278,201	6,721,799
Цэцэрлэг	14,000,000	21,922,159	27	29,650,000	7,727,841	6,272,159
Чандмань-Өндөр	14,000,000	25,476,528	9	33,100,000	7,623,472	6,376,528
Шинэ-Идэр	14,000,000	32,777,831	15	38,450,000	5,672,169	8,327,831
Эрдэнэбулган	14,000,000	17,471,515	9	22,800,000	5,328,485	8,671,515
Мөрөн	80,000,000	101,911,527	51	156,600,000	54,688,473	25,311,527
Дүн	400,000,000	712,967,561	516	921,647,600	208,680,039	191,319,961

Судалгаа гаргасан: Ахлах аудитор *Няма* Г.Нямлхагва
 Шинжээч *Б.Сандуйжав* Б.Сандуйжав

Хавсралт №2.1

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ҮЛДЭГДЛИЙН СУДАЛГАА

Сум	2009			
	Нийт санхүүжилт	Өрхийн тоо	олгосон зээл	олгогдоогүй зээлийн үлдэгдэл
Алаг-Эрдэнэ	14,000,000	9	14,097,600	(97,600)
Арбулаг	14,000,000	12	14,000,000	-
Баянзүрх	14,000,000	9	14,000,000	-
Бүрэнтогтох	14,000,000	3	12,000,000	2,000,000
Галт	14,000,000	4	7,000,000	7,000,000
Жаргалант	14,000,000	12	13,500,000	500,000
Их-Уул	14,000,000	5	14,000,000	-
Рашаант	14,000,000	3	7,000,000	7,000,000
Ренчинлхүмбэ	14,000,000	14	14,000,000	-
Тариалан	14,000,000	14	12,500,000	1,500,000
Тосонцэнгэл	14,000,000	9	11,200,000	2,800,000
Төмөрбулаг	14,000,000	8	14,000,000	-
Түнэл	14,000,000	2	7,000,000	7,000,000
Улаан-Уул	14,000,000	12	14,500,000	(500,000)
Ханх	14,000,000	4	11,000,000	3,000,000
Хатгал	12,000,000	16	10,700,000	1,300,000
Цагааннуур	14,000,000	12	14,000,000	-
Цагаан-Уул	14,000,000	5	14,000,000	-
Цагаан-Үүр	14,000,000	3	14,000,000	-
Цэцэрлэг	14,000,000	7	10,100,000	3,900,000
Чандмань-Өндөр	14,000,000	2	8,500,000	5,500,000
Шинэ-Идэр	14,000,000	5	14,000,000	-
Эрдэнэбулган	14,000,000	5	10,400,000	3,600,000
Мөрөн	80,000,000	31	70,600,000	9,400,000
Дүн	400,000,000	206	346,097,600	53,902,400

Хавсралт №2.2

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ҮЛДЭГДЛИЙН СУДАЛГАА

Сум	2010					
	Зээлийн эх үүсвэрийн эхний үлдэгдэл	Эргэн төлөлт	Өрхийн тоо	Олгосон зээл	Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл	Зээлийн эх үүсвэр
Алаг-Эрдэнэ	(97,600)	6,861,223	3	2,000,000	9,236,377	4,763,623
Арбулаг	-	5,270,883			8,729,117	5,270,883
Баянзүрх	-	12,827,384	8	10,100,000	11,272,616	2,727,384
Бүрэнгогтох	2,000,000	12,000,000	1	2,000,000	2,000,000	12,000,000
Галт	7,000,000	13,229,675	6	12,000,000	5,770,325	8,229,675
Жаргалант	500,000	15,626,173	15	14,100,000	11,973,827	2,026,173
Их-Уул	-	10,902,482	3	6,000,000	9,097,518	4,902,482
Рашаант	7,000,000	1,270,109	2	7,000,000	12,729,891	1,270,109
Ренчинлхүмбэ	-	3,997,903			10,002,097	3,997,903
Тариалан	1,500,000	12,473,649	6	11,950,000	11,976,351	2,023,649
Тосонцэнгэл	2,800,000	9,375,184	4	5,500,000	7,324,816	6,675,184
Төмөрбулаг	-	9,877,587	4	6,000,000	10,122,413	3,877,587
Түнэл	7,000,000	9,796,549	3	7,000,000	4,203,451	9,796,549
Улаан-Уул	(500,000)	5,487,536			9,012,464	4,987,536
Ханх	3,000,000	6,581,985	5	5,900,000	10,318,015	3,681,985
Хатгал	1,300,000	9,163,631	12	9,200,000	10,736,369	1,263,631
Цагааннуур	-	15,711,014	9	15,300,000	13,588,986	411,014
Цагаан-Уул	-	14,000,000				14,000,000
Цагаан-Үүр	-	14,000,000				14,000,000
Цэцэрлэг	3,900,000	12,534,442	4	3,900,000	1,465,558	12,534,442
Чандмань-Өндөр	5,500,000	9,968,656	1	5,500,000	4,031,344	9,968,656
Шинэ-Идэр	-	13,242,694	5	11,900,000	12,657,306	1,342,694
Эрдэнэбулган	3,600,000	8,001,110			2,398,890	11,601,110
Мөрөн	9,400,000	70,828,014	5	12,000,000	11,771,986	68,228,014
Дүн	53,902,400	303,027,883	96	147,350,000	190,419,717	209,580,283

Хавсралт №2.3

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ҮЛДЭГДЛИЙН СУДАЛГАА

Сум	2011					
	Зээлийн эх үүсвэрийн эхний үлдэгдэл	Эргэн төлөлт	Өрхийн тоо	Олгосон зээл	Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл	Зээлийн эх үүсвэр
Алаг-Эрдэнэ	4,763,623	12,686,539	12	15,600,000	12,149,838	1,850,162
Арбулаг	5,270,883	11,788,321	7	13,000,000	9,940,796	4,059,204
Баянзүрх	2,727,384	16,710,341	10	15,600,000	10,162,275	3,837,725
Бүрэнтогтох	12,000,000	3,191,990	2	10,500,000	9,308,010	4,691,990
Галт	8,229,675	5,208,559	6	11,550,000	12,111,766	1,888,234
Жаргалант	2,026,173	13,891,018	15	18,700,000	16,782,809	(2,782,809)
Их-Уул	4,902,482	9,105,703	6	14,000,000	13,991,815	8,185
Рашаант	1,270,109	8,490,689	5	13,200,000	17,439,202	(3,439,202)
Ренчинлхүмбэ	3,997,903	10,113,807	5	14,000,000	13,888,290	111,710
Тариалан	2,023,649	17,516,142	4	12,500,000	6,960,209	7,039,791
Тосонцэнгэл	6,675,184	9,360,079	8	13,500,000	11,464,737	2,535,263
Төмөрбулаг	3,877,587	16,207,191	13	14,950,000	8,865,222	5,134,778
Түнэл	9,796,549	4,203,451				14,000,000
Улаан-Уул	4,987,536	9,041,350	4	7,000,000	6,971,114	7,028,886
Ханх	3,681,985	15,695,823	11	13,200,000	7,822,192	6,177,808
Хатгал	1,263,631	14,772,458	10	12,800,000	8,763,911	3,236,089
Цагааннуур	411,014	20,588,986	9	18,000,000	11,000,000	3,000,000
Цагаан-Уул	14,000,000	-	9	14,000,000	14,000,000	-
Цагаан-Үүр	14,000,000	1,910,000	7	14,000,000	12,090,000	1,910,000
Цэцэрлэг	12,534,442	5,925,320	8	8,950,000	4,490,238	9,509,762
Чандмань-Өндөр	9,968,656	4,378,772	5	15,200,000	14,852,572	(852,572)
Шинэ-Идэр	1,342,694	13,871,614	5	12,550,000	11,335,692	2,664,306
Эрдэнэбулган	11,601,110	3,083,210	4	12,400,000	11,715,680	2,284,320
Мөрөн	68,228,014	19,350,894	11	41,500,000	33,921,092	46,078,908
Дүн	209,580,283	247,092,257	176	336,700,000	280,027,460	119,972,540

Хавсралт №2.4

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ҮЛДЭГДЛИЙН СУДАЛГАА

Сум	2012					
	Зээлийн эх үүсвэрийн эхний үлдэгдэл	Эргэн төлөлт	Өрхийн тоо	Олгосон зээл	Зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл	Зээлийн эх үүсвэр
Алаг-Эрдэнэ	1,850,162	9,856,626	1	5,000,000	7,293,212	6,706,788
Арбулаг	4,059,204	4,944,211			4,996,585	9,003,415
Баянзүрх	3,837,725	9,444,000			718,275	13,281,725
Бүрэнтогтох	4,691,990	7,738,518			1,569,492	12,430,508
Галт	1,888,234	7,979,079			4,132,687	9,867,313
Жаргалант	(2,782,809)	15,938,103	5	6,100,000	6,944,706	7,055,294
Их-Уул	8,185	6,050,330	2	5,500,000	13,441,485	558,515
Рашаант	(3,439,202)	12,512,031			4,927,171	9,072,829
Ренчиклхүмбэ	111,710	2,877,668			11,010,622	2,989,378
Тариалан	7,039,791	6,971,555	8	13,600,000	13,588,654	411,346
Тосонцэнгэл	2,535,263	4,193,834			7,270,903	6,729,097
Төмөрбулаг	5,134,778	8,093,738			771,484	13,228,516
Түнал	14,000,000	(878,706)			878,706	13,121,294
Улаан-Уул	7,028,886	2,670,670	2	6,000,000	10,300,444	3,699,556
Ханх	6,177,808	7,236,956			585,236	13,414,764
Хатгал	3,236,089	8,273,761	4	6,000,000	6,490,150	5,509,850
Цагааннуур	3,000,000	(535,435)	3	6,200,000	17,735,435	(3,735,435)
Цагаан-Уул	-	6,293,849			7,706,151	6,293,849
Цагаан-Үүр	1,910,000	4,811,799			7,278,201	6,721,799
Цэцэрлэг	9,509,762	3,462,397	8	6,700,000	7,727,841	6,272,159
Чандмань-Өндөр	(852,572)	11,129,100	1	3,900,000	7,623,472	6,376,528
Шинэ-Идэр	2,664,308	5,663,523			5,672,169	8,327,831
Эрдэнэбулган	2,284,320	6,387,195			5,328,485	8,671,515
Мөрөн	46,078,908	11,732,619	4	32,500,000	54,688,473	25,311,527
Дүн	119,972,540	162,847,421	38	91,500,000	208,680,039	191,319,961

Хавсралт №3



ХААН БАНК

УБД - 9016001011
ХӨВСГӨЛ АЙМАГ

Утас: (976-01-382) 22364
Факс: (976-01-382) 23824

2012 оны 09 сарын 20

Дугаар 805

Мөрөн сум

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР-т

ЖДҮ-ийг дэмжих төслийн
ээзлийн тухай

УИХ-ын гишүүн Ц. Даваасүрэнгийн багцаас олгогдож байгаа ЖДҮ-ийг дэмжих 400.0 сая төгрөгийн төслийн эзэлээс 2012-08-31-ний байдлаар олгогдох боломжтой буцаан төлөгдсөн 191.3 сая төгрөг, УИХ-ын гишүүн Ц. Сэвдэнчигийн багцаас олгогдож байгаа Бүс нутгийн хөгжлийг дэмжих сангийн 155.0 сая төгрөгийн эзэлээс 2012-08-31-ний байдлаар олгогдох боломжтой буцаан төлөгдсөн 10.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Хүндэтгэсэн:



ЗАХИРАЛ

[Handwritten signature] Д.НЭЦГЭЭ

ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН

ХААН БАНК ГҮНЖЛЭЛИЙН ХУУЛЬ

ОТМО : 2012.01.01 - 2012.09.18
ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН
ХЭРГЭЛЭГ : УИХЫН ГИШҮҮН Ц. СЭВДЭНЧИГИЙН

ОТМО	ТӨ	ИТ	ХӨШ	ХӨР	Дэвт	Хуви	Харгалзан дэмж	Төлбөрийн үйл
1	12.08.29	89006	20045	925282		555,000,000.00	5890022100000000	ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН ДЭМЖИЙН
					00000	555,000,000.00		
					Дэмж	000.00		
					Хэргэ	555,000,000.00		



ТООЦОО НИЙЛСЭН АКТ

2012.1.10

Мөрөн сум


Нэг талаас Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхтуяа, нөгөө талаас ХААН банкны Хөвсгөл салбарын ерөнхий нягтлан бодогч Ч.Оюунтөгс нар 2011 оны 9 сарын 26-ны өдрийн Хөвсгөл аймгийн ЗДТГ, ХААН банкны Хөвсгөл салбарын хооронд байгуулсан " Аймаг орон нутгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжин ажиллах талаар хамтран ажиллах гэрээ"-ний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгийн багцаас ХААН банкинд 400.000.000 /Дөрвөн зуун сая/ төгрөгийг дараах сумдын иргэд аж ахуйн нэгжид эзэл олгох санхүүжилтийн эх үүсвэр хэлбэрээр байршуулсныг баталгважуулан тооцоо нийлсэн болно. Үүнд:

№	Сумын нэр	Дүн /сая төгрөгөөр/
1	Алаг-Эрдэнэ	14.0
2	Арбулаг	14.0
3	Баянзүрх	14.0
4	Бүрэнтогтох	14.0
5	Галт	14.0
6	Жиргалант	14.0
7	Их-Уул	14.0
8	Рашаант	14.0
9	Рэнчинлхүмбэ	14.0
10	Тариалан	14.0
11	Тосонцэнгэл	14.0
12	Төмөрбулаг	14.0
13	Түнэл	14.0
14	Улаан-Уул	14.0
15	Ханх	14.0
16	Хатгал	12.0
17	Цагаан-Уул	14.0
18	Цагааннуур	14.0
19	Цагаан-Үүр	14.0
20	Цэцэрлэг	14.0
21	Чандмана-Өндөр	14.0
22	Шинэ-Идэр	14.0
23	Эрдэнэбулган	14.0
24	Мөрөн	80.0
	Нийт дүн	400.0

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын
СТСХ-ийн ерөнхий нягтлан
бодогч Ц.Мөнхтуяа




ХААН банкны Хөвсгөл аймгийн
салбарын ерөнхий нягтлан
бодогч Ч.Оюунтөгс



1400000000 үсэг
Ц.Мөнхтуяа
2012.01.10

Хавсралт №5



2011 оны ᠙᠘ дугаар сарын ᠘-ны өдөр

№ 0᠘

Мөрөн хот

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар /Цаашид "А" тал гэх/, нөгөө талаас ХААН банкны Хөвсгөл салбар /Цаашид "В" тал гэх/, хамтад нь /Талууд гэх/ нар харилцан тохиролцож дараах нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Хөвсгөл аймгийн 24 сумдал /Хавсралтад заасан/ өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тухайн сумын иргэд, аж ахуйн нэгжид зээл олгох, гэрээнд оролцогч Талуудын хамтын ажиллагааны явцад талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ гэрээг амжилттай хэрэгжүүлэх үүднээс зээлд хамрагдах, иргэн, аж ахуйн нэгж нь бизнесийн тодорхой туршлагатай, үйл ажиллагаа нь тогтворжсон, тодорхой хэмжээний эрсдэл болон хариуцлага хүлээх чадвартай байх зарчмыг баримтална.

ХОЁР. ГОЛ НӨХЦӨЛ

- 2.1. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг тухайн суманд "Төсөл шалгаруулах хороо" байгуулж хэлэлцэж, шийдвэрлэнэ. Уг хороо нь Сумын Иргэдийн Хурлын 2 төлөөлөгч (намуудын төлөөлөл), Сумын Засаг дарга, Сумын засаг даргын орлогч, аж ахуйн нэгжийн 1 төлөөлөл, иргэний 2 төлөөлөл нийт 7 хүнтэй байна. Иргэний төлөөллийг сумын иргэд хуралдаж дундаасаа, аж ахуйн нэгжийн төлөөллийг сумын Ажил олгогч эздийн холбооны хурлаас тус тус сонгосон байна. Хорооны дарга нь Сумын Засаг дарга байна.
- 2.2. Зээлийн нийт дүн: Энэ гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд сумдын иргэд, аж ахуйн нэгжид зээл олгох санхүүжилтийн нийт дүн нь 400.000.000 /Дөрвөн зуун сая/ төгрөг байх ба Мөрөнд 80.0 сая, Хатгалд 12.0 сая, бусад сумдал 14.0 сая төгрөгийн эх үүсвэр зарцуулна.
- 2.3. Мөнгөн хөрөнгө байршуулах: "А" талын байршуулах мөнгөн хөрөнгийг "В" талын банкны 5890750177 тоот "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн санхүүжилт" нэртэй дансанд байршуулна. Зээлийн сангийн мөнгөн хөрөнгөнд гэрээний хугацаанд хүү тооцохгүй.
- 2.4. Нэг зээлдэгчид олгох зээлийн гол нөхцөлийг дараах байдлаар тогтоов. Үүнд:
 - 2.4.1. Зээлийн дээд хэмжээ: 10 сая хүртэл төгрөг
 - 2.4.2. Зээлийн хүү: сарын 1 хувь, жилийн 12 хувь.
 - 2.4.3. Зээлийн хугацаа: 24 хүртэл сар
 - 2.4.4. "В" талын зээлийн үйлчилгээний шимтгэл нь олгосон зээлийн дүнгийн 0,5 хувь байна.

- 2.4.5 Зээлдэгч нь зээл, хүүг гэрээгээр тохирсон хуваарийн дагуу төлөхгүй тохиолдолд гэрээний үүргээ биелүүлж дуусах хүртэл хугацаанд хуульд заасны дагуу зээлийн үлдэгдлээс үндсэн хүүг 20 хувиар нэмэгдүүлж тооцно. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон зээлийн гэрээ байгуулж, батлуулахтай холбоотой зардлыг зээлдэгч хариуцана.
- 2.4.6 Хавсралтад заасан сумдын захиргааны харъяалалд байнга оршин суудаг бөгөөд “В” талын зээлийн журмын шаардлага хангасан этгээдэд олгох
- 2.4.7 Зээлийг зөвхөн үйлдвэрлэл эрхлэгч иргэд аж ахуйн нэгжид олгох бөгөөд худалдааны санхүүжилт болон хувийн хэрэгцээнд олгохгүй байх

2.5 Гэрээний хугацаа: 24 сарын хугацаанд үйлчилнэ. Олгосон зээлийн хугацаа нь гэрээний үйлчлэх хугацаанаас хэтэрсэн тохиолдол ч энэ гэрээний зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. “А” тал дараах эрх, үүрэгтэй:

- 3.1.1. Энэ гэрээний хүрээнд “В” талд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх талаар хяналт тавих эрхтэй.
- 3.1.2. “Төсөл шалгаруулах хороо”-оос судалж ирүүлсэн зээлдэгч нар зээл, хүүгийн төлбөрийг хугацаандаа эргүүлэн төлөхгүй байгаа тохиолдолд сумын Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, зээлийг төлүүлэх талаар “В” талтай хамтран ажиллах.
- 3.1.3. Мөнгөн хөрөнгийг энэ гэрээгээр тохиролцсон хугацаанд “В” талын Хөвсгөл аймаг дахь ХААН Банкны Хөвсгөл салбарын “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн санхүүжилт” нэртэй 5890750177 тоот харицах дансанд шилжүүлэх үүрэгтэй.
- 3.1.4. “А” тал нь сумдын иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээл эргэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд ХААН Банкнаас эх үүсвэрийг буцаан татахгүй байх үүрэгтэй.
- 3.1.5. “В” талыг гэрээнд заасан үүргийнхээ дагуу шуурхай шударга ажиллахыг шаардах эрхтэй.
- 3.1.6. Сангийн ажлын тайлантай тогтоосон хугацаанд танилцах эрхтэй.
- 3.1.7. “А” тал нь зөвхөн сумын Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцэж, баталсан төслийг “В” талд хүргүүлэх үүрэгтэй.
- 3.1.8. Санал болгож байгаа төслийн зохиогч, зээл хүсэгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тодорхойлолтыг “В” талд гаргаж өгөх үүрэгтэй.
- 3.1.9. “В” талын ажилтныг суманд ажиллах нөхцөлд хэвийн ажиллах нөхцөл буюу ажлын байр, боломжит бусад зүйлээр хангах үүрэгтэй.
- 3.1.10. “А” тал нь Төсөл шалгаруулах хороонд төсөл шалгаруулахад “В” талын өгсөн зөвлөмжийг удирдлага болгон ажиллахыг шаардах.
- 3.1.11. “В” талын дотоод ажилд оролцох, түүний үйл ажиллагаанд зүй бусаар хутгалдах, дарамт, шахалт үзүүлэх замаар нөлөөлөхийг хориглоно.

3.2. “В” тал дараах эрх, үүрэгтэй.

- 3.2.2. Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцсэн төслүүдийг судлах, дүгнэлт гаргах болон шийдвэрлэхдээ зөвхөн өөрийн байгууллагын дотоод журам, зааврыг баримтлах ба зээл олгох эсэх шийдвэрийг бие даан гаргана. “В” тал нь уг хороогоор хэлэлцэж, батлаагүй төслийг хүлээн авахгүй байх эрхтэй.
- 3.2.3. Зээлийг зөвхөн энэхүү гэрээний 1.1-д заасан сумдын захиргааны харъяалалд байнга оршин суудаг бөгөөд “В” талын зээлийн журмын шаардлага хангасан этгээдэд олгох


- 3.2.4. Энэ гэрээгээр тохиролцсон хүүгийн түвшинг баримтлан сумдын иргэд, аж ахуйн нэгжид зээл олгоно.
- 3.2.5. Зээлдэгч нь зээл, хүүг гэрээгээр тохирсон хуваарийн дагуу төлөхгүй тохиолдолд гэрээний үүргээ биелүүлж дуусах хүртэл хугацаанд хуульд заасны дагуу зээлийн үлдэгдлээс үндсэн хүүг 20 хувиар нэмэгдүүлж тооцож авах эрхтэй.
- 3.2.6. Хугацаа хэтэрсэн зээлтэй Зээлдэгчийн талаар "А" талд мэдэгдэх, шийдвэрлэх талаар хамтран ажиллах санал, хүсэлт гаргах эрхтэй.
- 3.2.7. "В" тал нь сумдын иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээл эргэн төлөгдөж дуусахад эх үүсвэрийг буцаан шилжүүлнэ.
- 3.2.8. Энэ гэрээний гүйцэтгэлийг хангах, үр дүнг дээшлүүлэх асуудлаар "А" талд санал хүсэлт гаргах, шаардах эрхтэй.
- 3.2.9. "В" тал нь "Төсөл шалгаруулах хороо"-нд зээл судлахад зайлшгүй удирдлага болгох зөвлөмжийг гаргаж өгөх үүрэгтэй. Энэхүү зөвлөмжинд зээл судлахад зайлшгүй бүрдүүлэх материал, барьцаа хөрөнгийн шаардлагын талаар заасан байна.
- 3.2.10. Зээлийн судалгаа хийх, шийдвэрлэх, олгох, зээлд хяналт тавих, эргэн төлөлттэй холбогдон гарч болох бүх эрсдлийг "В" тал хариуцна.
- 3.2.11. Байгалийн болон давагдашгүй хүчний нөлөөлөл, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт, цэргийн болон дайн бүхий байдал үүсч, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсноос үүсэх эрсдэлийг "В" тал хариуцахгүй.
- 3.2.12. Сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийн тухай ерөнхий тоон мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаж, "А" талд мэдэгдэнэ.
- 3.2.13. Харилцагчийн нууцлалын асуудал нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагдана.
- 3.2.14. "В" тал бусад талуудад сар бүр зээлийн үйл ажиллагааны тайлан гаргаж хүргүүлэх ба тайлангийн маягтыг гэрээний хавсралтаар батална.

Доргов . БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Энэ гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.2. Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд гэрээг цуцлах тухай Талуудаас санал гаргаагүй тохиолдолд гэрээний хугацаа анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 5.3. Гэрээг энэхүү гэрээний 2.3 болон 2.4 дэх заалтууд зөрчигдсөн болон гэрээний харилцаатай холбоотой ноцтой зөрчил гарсанаас бусад тохиолдолд нэг талын санаачлагаар цуцлахгүй. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар санал гаргагч Тал нөгөө Талд албан бичгээр ажлын 30 хоногт багтаан мэдэгдэж, Талуудын зөвшилцсөнөөр протокол үйлдэж нэмэлт, өөрчлөлт оруулна. Протокол болон нэмэлт гэрээ нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.4. Гэрээ нь хавсралтын хамт 2. (хоёр /үсгээр/) хуудас бөгөөд ... /Могоо... хотноо 200/ оны 08-р сарын 26- ны өдөр 2. (хоёр /үсгээр/) эх хувь үйлдсэн болно. Талууд холбогдох хувийг хадгалах ба хувь тус бүр адил хүчинтэй.
- 5.5. Энэхүү гэрээ байгуулагдсанаар энэ асуудлаар өмнө нь байгуулагдсан бүх гэрээ, хэлцэл, тохиролцоо хүчингүй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗДТГазрын Хөгжлийн
бодлогын хэлтэсийн дарга
Х.Ган-Очир



ХААН банк Хөвсгөл салбарын
Ахлах эдийн засагч





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2012 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав, ХААН банкны захирал Д.Цэцгээ, сумдын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2013 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав, ХААН банкны захирал Д.Цэцгээ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэг, Хөвсгөл аймгийн Ерөнхий аудитор О.Ганболд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД